



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 466

Улаанбаатар хот

### 「Хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүр, журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 24.1.5, 37.2.5, 38.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал, түүний бүрэлдэхүүн"-ийг 1 дүгээр хавсралт, "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын байршил, суралцагчийн тооны болон мэргэжлийн ерөнхий чиглэл, тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн итгэлцүүр"-ийг 2 дугаар хавсралт, "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийг үр дүнд суурилсан хэлбэрээр болон олон улсын жишиг хөтөлбөрт нийцүүлэн санхүүжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

3. Цэрэг, цагдаа, онцгой байдал, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг энэ тогтоолын 1 дэх заалтад заасан журмын дагуу санхүүжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай" Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 200 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХ-АМГАЛАН



**НЭГ.МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ  
СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДАЛ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН**

1.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага:

1.1.Нэг суралцагчид ногдох хувьсах зардал:

(Мянган.төгрөг)

№	Зардлын төрөл/Боловсролын түвшин	Техникийн боловсрол						Мэргэжлийн боловсрол		
		1.5 жил			3 жил			3 жил		
		I анги	II анги	I анги	I анги	II анги	III анги	I анги	II анги	III анги
1.	Хувьсах зардлын хэмжээ	2,457.7	1,220.3	3,562.5	2,260.0	2,527.5	2,847.5	2,685.5	2,777.0	2,887.5

1.2.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн:

(Мянган.төгрөг)

№	Бүрэлдэхүүн	Хувьсах зардлын хэмжээ
A	Нийт хувьсах зардал	-
1.	Багш, ажилтны үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	65.4%
2.	Багш, ажилтны нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	17.5%
3.	Сургалтын хэрэглэгдэхүүн	1.5%

4.	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.0%
5.	Дэдлага ажлын материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	8.6%
6.	Бусад хувьсах зардал	6.0%
Б	Нийт эх үүсвэр (хувь)	100%
1.	Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ	100%
2.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-

## 2.Хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага:

### 2.1.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ:

(Мянган.төгрөг)

№	Зардлын төрөл/Боловсролын түвшин	Техникийн боловсрол						Мэргэжлийн боловсрол		
		1.5 жил			3 жил			1 жил		
		I анги	II анги	I анги	II анги	III анги	I анги	II анги	III анги	
1.	Хувьсах зардлын хэмжээ	774.1	401.8	1,094.1	739.2	864.3	941.8	847.9	876.3	973.4

---000---

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 166 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН  
БАЙГУУЛЛАГЫН БАЙРШИЛ, СУРАЛЦАГЧИЙН  
ТООНЫ ИТГЭЛЦҮҮР

№	Байршил	Суралцагчийн тоон интервал	Итгэлцүүр
1.	Нийслэлд	1-500	1.3
		501-750	1.25
		751-1000	1.2
		1001-1500	1.15
		1501 түүнээс дээш	1
2.	Аймгийн төвд	1-500	1.7
		501-750	1.65
		751-1000	1.6
		1001-1500	1.55
		1501 түүнээс дээш	1.5
3.	Сумын төвд	1-200	2.0
		201-300	1.95
		301-400	1.9
		401-500	1.85
		501 түүнээс дээш	1.8

МЭРГЭЖЛИЙН ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛИЙН ИТГЭЛЦҮҮР

№	Салбарын ангилал	Мэргэжлийн боловсрол	Техникийн боловсрол
1.	Аялал жуулчлал	1.27	1.28
2.	Барилга, зам	1.06	1.04
3.	Боловсруулах үйлдвэрлэл	1.09	1.08
4.	Зочид буудал, нийтийн хоол	1.05	1.06
5.	Мэдээлэл, холбоо	1.08	1.08
6.	Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	1.05	1.04
7.	Соёл урлаг	1.08	1.07
8.	Тээвэр	1.01	1.01
9.	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх	1.18	1.13
10.	Уул уурхай	1.10	1.11
11.	Үйлчилгээ	1.10	1.09

12.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	1.27	1.26
13.	Эрчим хүч, дулаан	1.00	1.00
14.	Бусад	1.25	1.18

ТЭРГҮҮЛЭХ БОЛОН НЭН ШААРДЛАГАТАЙ  
МЭРГЭЖЛИЙН ИТГЭЛЦҮҮР

№	Мэргэжил	Итгэлцүүр
1.	Тэргүүлэх мэргэжил	1.5
2.	Нэн шаардлагатай мэргэжил	1.3

---o0o---

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27 -ны өдрийн 166 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

## ХУВЬСАХ ЗАРДАЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНД СУУРИЛАН САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг үндэслэн сургалтын үйл ажиллагааны зардал болон байгууллагын гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжилтийг тооцох, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд энэ журмыг мөрдөнө.

1.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийн ашиглалт, их засвар, дотуур байрны суралцагчийн хсэл, гэрээгээр гүйцэтгүүлж байгаа харуул хамгаалалт, багш, ажилтны нийгмийн баталгааны зардлыг нь хувьсах зардлын бүрэлдэхүүнд тооцохгүй.

1.3.Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн харьяа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар тооцож санхүүжүүлнэ.

1.4.Хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс нэг суралцагчид ногдох хувьсах зардлын санхүүжилт олгох үндэслэл нь байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, сургалтын үйл ажиллагааны хамрах хүрээ, тогтвортой байдал, үр дүнг илэрхийлсэн албан ёсны статистик, төсвийн төсөлд өгсөн санал, дээд шатны төсвийн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн гэрээ, гэрээнд туссан шалгуур үзүүлэлтийн биелэлт байна.

### Хоёр.Нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“Хувьсах зардал” гэж Боловсролын ерөнхий хуулийн 3.1.16-д заасныг;

2.1.2.“Олон улсын хөтөлбөр” гэж Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.13-т заасныг.

Гурав.Нэг суралцагчид ногдох хувьсах зардал,  
түүний бүрэлдэхүүн

3.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардалд үндэслэн олгох санхүүжилт нь боловсролын стандартыг хангах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сургалтын орчныг сайжруулах, хичээл, дадлагын үйл ажиллагааг хэвийн явуулах, хүний нөөц,

хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, захиргаа, удирдлагын болон дотуур байрны хэвийн үйл ажиллагаа, мэдээлэл, технологийн орчин бүрдүүлж, ном сурах бичгээр хангахад чиглэсэн үйл ажиллагааны зайлшгүй шаардлагатай урсгал зардалд хүрэлцэхүйц байна.

3.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хувьсах зардал нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.2.1.багш, ажилтны цалин хөлс, хууль тогтоомжид заасны дагуу түүнд ногдох нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал;

3.2.2.сургалтын үйл ажиллагаанд ашиглагдах сургалтын хэрэглэгдэхүүн, материалын зардал;

3.2.3.сургалт, дадлагын үйл ажиллагааны үеэр багш, суралцагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зардал;

3.2.4.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургууль дээр хийгдэх хичээл, дадлагын ажлын материалын зардал;

3.2.5.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах багшийг мэргэшүүлэх, давтан сургах, багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, дотуур байрны орчин нөхцөл, сургалтын багаж, тоног төхөөрөмж, мэдээлэл технологийн болон сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зардал;

3.2.6.цэрэг, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр, хил хамгаалах чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн цэргийн дүрэмт хувцасны зардал.

3.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг инфляц, улсын дундаж цалин хөлс болон эдийн засгийн өсөлтийг харгалзан хоёр жилд нэг удаа шинэчлэн батлуулж болох бөгөөд шаардагдах санхүүжилтийг дараа оны төсвийн төсөлд тусгана.

### Дөрөв.Хувьсах зардалд тохируулга хийх

4.1.Сургалтын хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлийн санхүүжилтийн онцлог байдлыг харгалзан нэг суралцагчид ногдох хувьсах зардалд доор дурдсан тохируулга хийж төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч хуваарилалт хийнэ:

4.1.1.өмчийн бүх хэлбэрийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтийг дараах томъёогоор тооцож нийт санхүүжилтийг тодорхойлно:

$$\text{Нийт санхүүжилт} = \sum_{k=0}^n \binom{n}{k} \text{СТ} * \text{БИ} * \text{ХИ} * \text{ХЗл} * \text{СИ} * \text{ГЗОТ}$$

СТ-Суралцагчийн тоо

БИ-Тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн итгэлцүүр

ХИ-Олон улсын хөтөлбөрийн итгэлцүүр

ХЗп-Сургалтын түвшингээс хамаарсан нэг суралцагчид ногдох хувьсах зардал

СИ-Мэргэжлийн ерөнхий чиглэлийн итгэлцүүр

ГЗОТ-Суралцагчийн тоо болон байршлын итгэлцүүр

4.1.2.өмчийн бүх хэлбэрийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ногдох хувьсах зардлыг гурав дахин нэмэгдүүлж тооцно.

4.2.Төсвийг тооцохдоо суралцагчийн тоог мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт хамрагдах албан ёсны статистикийн суралцагчийн тоогоор, дотуур байрны хувьд албан ёсны статистикийн суралцагчийн тооноос хэтрэхгүй байхаар тооцно.

4.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад шаардлагатай багшийн орон тоог тухайн хичээлийн жилд хамрагдах суралцагчийн тоо, хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг үндэслэн тодорхойлно.

Тав.Хувьсах зардал төлөвлөх, хуваарилах

5.1.Төсвийн шууд захирагч нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар тооцсон төсвийн төслийг тухайн жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамж, чиглэлд нийцүүлэн боловсруулж төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч саналыг хянан, нэгтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

5.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг энэ журмын 3.3-т заасны дагуу шинэчлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу санал боловсруулж батлуулна.

5.3.Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч батлагдсан төсвийг бодит тоо, мэдээлэлд үндэслэн нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар тооцоолж, төсвийн шууд захирагч тус бүрээр батална.

5.4.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын санхүүжилтийг төсвийн төвлөрүүлэн захирагч хянаж, баталсан хуваарьт нийцүүлэн сар бүр төсвийн шууд захирагчид олгоно.

5.5.Нэг суралцагчид ногдох хувьсах зардалд үндэслэн олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг суралцагч өдрөөр хянаж хагас, бүтэн жилээр тооцон зохих өөрчлөлтийг тусгаж болно.

5.6.Улсын хэмжээнд болон тухайн орон нутагт өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдал, онцгой нөхцөл байдал тогтоосон үед боловсролын байгууллагын танхимын сургалтыг онлайн, теле болон цахим хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд нэг суралцагчид ногдох өртөгт суурилсан хувьсах зардлыг тухайн хичээлийн жилийн албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн хуваарилна.



5.7. Давагдашгүй хүчин зүйл үүссэн, төсвийн захирагч нарын үйл ажиллагаа тогтворжоогүй байгаа нөхцөлд төсвийн ерөнхийлөн захирагч улсын хэмжээнд нийт төсвийн хуваарилалтыг сар бүрээр, байгууллагын нийт дүнгээр баталж мөрдүүлж болно.

### Зургаа. Хувьсах зардлыг санхүүжүүлэх

6.1. Төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага нэг суралцагчид ногдох хувьсах зардлын санхүүжилтийг зарцуулахдаа дараах зарчимд үндэслэнэ:

6.1.1. сургалтын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдах нөхцөлийг хангах;

6.1.2. сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай багшийн тоо, тухайн хичээлийн жилийн суралцагчийн тоонд үндэслэн сургалтын төлөвлөгөөг оновчтой баталж, мөрдүүлэх;

6.1.3. багшийн цалин хөлс, урамшууллыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэл, үр дүнг нь харгалзан тухайн сургалтын байгууллагын баталсан жилийн төсөвтөө багтаан олгох;

6.1.4. төсөвт байгууллагын өөрийн орлогын хэмжээг батлах, түүнийг захиран зарцуулах, багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, шийдвэр гаргахад удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, хамгийн өндөр эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлэх;

6.1.5. сургалтын байгууллагын төсөв хуваарилах, хэрэгжүүлэхэд ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах.

6.2. Төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, бусад ажилтны цалингийн санд үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, Засгийн газрын тогтоолоор баталсан бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөн олговор, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тус тус багтана.

6.3. Бүх шатны төсвийн захирагч хувьсах зардалд үндэслэн олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.

### Долоо. Төсвийн гүйцэтгэл, төлбөр тооцоо, тайлагналт

7.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан гаргана.

7.2. Төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргахдаа санхүүгийн программаар боловсруулж, мөнгөн гүйлгээний тайланд тохируулга хийж бэлтгэнэ.

7.3. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Төсвийн тухай хууль, холбогдох эрх зүйн актын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагч хянаж, нэгтгэн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ.

7.4.Төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага хөрөнгийн өөрчлөлтийг тухай бүр Боловсролын мэдээллийн санд оруулж, тайлагнана.

7.5.Цэрэг, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр, хил хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох дээд шатны байгууллагын төсвийн захирагчид тайлагнана.

#### Найм.Төсвийн удирдлага, зохион байгуулалт

8.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төсөв, санхүүгийн удирдлага нь Удирдах зөвлөл болон төсвийн шууд захирагчаас бүрдэнэ.

8.2.Удирдах зөвлөл мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын хэмжээг төсвийн жилийн эхний 10 хоногийн дотор хэлэлцэнэ.

8.3.Удирдах зөвлөл нэмэлт орлогын төлөвлөгөө, үйлчилгээний төлбөрийн хэмжээ байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, онцлогт тохируулан зарцуулах зориулалтыг батална.

8.4.Удирдах зөвлөл батлагдсан төсөвт багтаан тухайн жилд мөрдөх орон тооны хязгаар, багш ажилтны цалин хөлс, урамшууллын хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэнэ.

8.5.Тухайн жилийн төсөв нь дээд шатны төсвийн захирагчтай байгуулсан хувьсах зардлын санхүүжилтээр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тодорхойлсон гүйцэтгэлийн гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хангах боломжтой байна.

8.6.Дээд шатны төсөвт нэмэлт, өөрчлөлт хийгдсэний улмаас тухайн шатны төсөвт нэмэлт, өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага бий болсон, урьдчилсан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсөвт байгууллагын төлөвлөсөн орлогын хэмжээнд өөрчлөлт орох, зардал нэмэгдэх нөхцөл бий болсон тохиолдолд тухайн жилийн батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах төсвийн шууд захирагчийн саналыг Удирдах зөвлөлөөр хэлэлцэнэ.

#### Ес.Гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилт

9.1.Энэ журмын 8.5-д заасан гүйцэтгэлийн гэрээ нь төсвийн шууд захирагч болон дээд шатны төсвийн захирагч хооронд байгуулагдах бөгөөд салбарын бодлого, түүнийг хэрэгжүүлэх үндсэн шалгуур үзүүлэлт, тусгай шалгуур үзүүлэлтийг багтаасан байна.

9.2.Гүйцэтгэлийн гэрээ, түүнд заасан шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүнг Боловсролын ерөнхий хуулийн 17.11-д заасан байгууллага үнэлж дараа оны 1 дүгээр сард багтаан үр дүнг төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ.

9.3. Гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилт нь гүйцэтгэлийн гэрээний үр дүнг тооцсоны үндсэн дээр улсын төсвөөс олгох нэмэлт санхүүжилт байх бөгөөд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хувьсах зардлаар тооцсон тухайн төсвийн жилд улсын төсвөөс олгох санхүүжилтийн арав хүртэлх хувь байна.

9.4. Гүйцэтгэлийн гэрээний биелэлт, үр дүнг төсвийн төвлөрүүлэн захирагч хянаж гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилтийг дараах хувь хэмжээгээр тооцон олгоно:

Биелэлт	Гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилт
Шалгуур үзүүлэлтийн биелэлт 90-100 хувь биелсэн	100 хувь
Шалгуур үзүүлэлтийн биелэлт 80-89.9 хувь биелсэн	80 хувь
Шалгуур үзүүлэлтийн биелэлт 70-79.9 хувь биелсэн	70 хувь
Шалгуур үзүүлэлтийн биелэлт 60-69.9 хувь биелсэн	60 хувь
Шалгуур үзүүлэлтийн биелэлт 59.9-өөс доош хувиар биелсэн	50 хувь

9.5. Гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилтийн 60 хувийг багш, ажилтны үр дүнгийн үнэлгээний урамшуулалд, 40 хувийг Удирдах зөвлөлийн шийдвэрээр зохих урсгал зардлын зориулалтаар зарцуулна.

#### Арав. Төсвийн хяналт

10.1. Төрийн сан нь төсвийн зарцуулалтыг хөтөлбөр, зориулалт, арга хэмжээний ангиллаар хянаж, санхүүжилт олгоно.

10.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас өгсөн чиглэл, батлагдсан төсвийн хуваарилалт, энэ журмын дагуу холбогдох албан хаагч төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналтыг удирдан зохион байгуулна.

10.3. Бүх шатны төсвийн захирагч нь төрийн сангийн төлбөр тооцооны системээр дамжуулан төсвийн хуваарилалт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавина.

10.4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсролын сургалтын байгууллагын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэл, тайлагналтыг цахим мэдээллийн системд үндэслэн гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байна. Цахим систем нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд ашиглаж байгаа цахим системтэй мэдээлэл солилцох, харилцан уялдаатай ажиллах боломжтой байна.

10.5. Төрийн албаны цалингийн мэдээллийн систем дэх цалингийн гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон боловсролын мэдээллийн систем хөрвүүлж авах бөгөөд энэ нь салбарын орон тоо, цалингийн сангийн албан ёсны суурь мэдээлэл болно.

10.6.Төрийн сангийн төлбөр тооцооны системээс гаргасан мэдээлэлд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программаар боловсруулсан боловсролын салбарын байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож, дараагийн сарын 05-ны өдрийн дотор боловсролын цахим мэдээллийн системд хөрвүүлсний үндсэн дээр салбарын төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэнэ.

---o0o---